



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
АНАГААХ УХААНЫ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН
ХОРООНЫ ТОГТООЛ**

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 26/003

Улаанбаатар хот

「Судалгааг эхлүүлэх зөвшөөрөл олгох тухай」

Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 26/01 дүгээр хурлын протоколыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Насанд хүрсэн Монгол хүн амын дунд тохиолдох гэдэс-тархины харилцан үйлчлэлийн эмгэгийг үнэлэх Ром IV шалгуурыг нутагшуулах нь” сэдэвт судалгааны төслийг судлаач, Анагаах ухааны доктор Гидаагаяа овогтой Сарантуяагийн удирдлаган дор 2026-2027 онд багтаан хэрэгжүүлж, гүйцэтгэхийг зөвшөөрсүгэй.

2. Судалгааны явцад тодорхой шалтгааны улмаас арга аргачлал өөрчлөгдөх, гадаад орон руу сорьц тээвэрлэх, Хельсинкийн тунхаглалд туссан ёс зүйн асуудал хөндөгдсөн тохиолдолд Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороонд мэдэгдэж, дахин хэлэлцүүлэхийг судалгааны удирдагч болон багийнханд үүрэг болгосугай.

3. Судалгааны явцын тайланг Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороонд ирүүлэхийг төслийн удирдагчид үүрэг болгосугай.

4. Судалгааны төгсгөлийн тайланг Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, судалгаа дууссан хугацаанаас хойш 2 сарын дотор багтаан Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороонд ирүүлэхийг төслийн удирдагчид үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.МӨНХЦЭЦЭГ